

Улсыг батлан хамгаалах стратегийн нэг нь орон нутгийн хамгаалалт мөн

Б.Ширнэн

БХЯ-ны Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны газар

Key words:

National Defense
Guarantee, Local
Defense.

Abstract: Local defense has long been one of the traditional ways for Mongolians to protect their homeland and pastures. In the 21st century, volunteer armed groups played a role alongside the modern army in the struggle for Mongolia's independence and in the wars. Although the Mongolian traditional cavalry for thousands of years has become a modern mechanized and motorized infantry, the importance of local defense has not diminished. After the collapse of the USSR, Mongolia spent a lot of time searching for new ways to ensure its security. It became clear that the Armed Forces alone could not protect our country with its vast territory, small population, and weak economy. However, the Mongolians, united in spirit, will, and values, and the legalization of a unified defense system with citizen participation, have guaranteed our country's security. In the future, developing and strengthening local defense is an important issue in the defense sector.

Удиртгал

Монгол Улс эрт үеэс эр цэрэг, өрхийн цэрэг нэртэйгээр нутаг дэвсгэрээр зохион байгуулагдан орон нутгаа хамгаалж ирсэн уламжлалтай билээ.

Тиймээс орон нутгийн хамгаалалт нь шинээр гарч ирсэн ойлголт бус, харин монголчуудын цэргийн эрдэм ухааны нэгэн хэсэг, улс орны тусгаар тогтнол, хил хязгаарын дархан байдлыг батлан хамгаалах, орон нутаг, бэлчээр газраа хамгаалах үйл ажиллагааны салшгүй хэсэг байсаар ирсэн гэж үзэж болох юм.

Түүхийг сөхвөл Их Монгол Улс задарч, доройтсон. Чингис хааны үеийн Их Монгол улсын газар нутаг, хүн ам, олон улсын нэр төр, цэрэг-зэвсгийн чадавх, эдийн засгийн хүчин чадал, төр засгийн хүчирхэг бодлого, тогтолцоо, дэлхийн цар хүрэн дэх нөлөө, хамаарал үлэмж унаж доройтоод 1911 оны үед өрөвдөлтэй, арчаагүй байдалтай байсан¹.

Товчхондоо бүрэн дуунаар өрх бүрээс бүрэн зэвсэгтэй нэг баатар эр гарч ирдэг байсан нь өөрчлөгдөж, нэг лам гарч ирсэн. Энэ бүхнийг өөрчлөх зайлшгүй шаардлагатай байлаа.

¹ Д. Чулуунжав, “Монголын уналт, доройтлын нэг гол шалтгаан нь ламын шашин, мухар сүсэг” нийтлэл, 2017.04.21, <https://sonin.mn/news/politics-economy/77019>

Нэг. Орон нутгийн хамгаалалтын түүхээс ...

1921 оноос байгуулагдсан Монголын Ардын Журамт Цэргийн бүрэлдэхүүнд “нутгийн цэрэг” нэртэй бүтэц, нэгж багтаж байв. Тухайн орон нутагт цэргүүдийг татаж, сургаад орон нутаг, улсын хил хязгаарыг хамгаалах үүрэг гүйцэтгүүлж байснаас гадна гэр майхан, хоол хүнс, уналга зэрэг бараа, материалыг орон нутгаас бэлтгэн нийлүүлж ашиглаж байжээ. Энэ нь Монголын хүн ам, газар нутаг, ахуйн соёлын орны нөхцөлд илүү тохиромжтой, газар нутгаа хамгаалах цэргийн зохион байгуулалтын нэг уламжлалт хэлбэр болж байв².

1930-иад онд Монголын Ардын Хувьсгалт цэрэг үлэмж бэхжиж, орчин үеийн байнгын армийн бүтэц, зохион байгуулалтад орж, шинэ зэвсэг техник, нисэх онгоцоор хангагдаж эхэлсэн. Мөн түүнчлэн, байнгын армийн хажуугаар түүнд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий орон нутгийн сайн дурын зэвсэгт бүлэглэлүүд үйл ажиллагаа явуулсан. Тухайлбал, 1939 онд нэг талдаа ЗХУ/БНМАУ-ын цэрэг, нөгөө талд Япон/Манж-Го Улсын цэргийн хооронд болсон Халхын голын дайнд байнгын армийн цэргүүдээс гадна сайн дурын морьт отрядууд оролцож, агт морь хариулах, туршуул хийх, ачаа бараа, зам, худаг ус хамгаалах зэрэг туслах чанарын үүргийг гүйцэтгэж байлаа.

1942 онд улс орныг батлан хамгаалах ажилд олон түмнийг өргөн хүрээтэй оролцуулах шаардлага тулгарч байгааг харгалзан аравт, тавьт, зуут, мянгат, түмт гэсэн зохион байгуулалт бүхий “Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд” байгуулсан. Энэ отряд Улаанбаатар хот болон бүх аймаг, сум, үйлдвэр, албан газарт байгуулагдаж, хөдөлмөрчдийг буудлага, гранат шидэх, жагсаал, биеийн тамир болон зэвсэг техник эзэмших арга эзэмшүүлэх сургалтад хамруулж байв. Үүний зэрэгцээ, ард олныг дайсны агаарын дайралт, химийн хордолтоос хамгаалах арга ажиллагаанд сургаж, цаг агаар, газар орны хүндрүүлсэн нөхцөлд хээрийн дадлага сургууль хийлгэж байжээ. Тус отряд нь тугтай, гишүүд нь малгай, тэмдэг зэрэг тусгай хувцастай цэрэгжсэн байгууллага байсан юм. 1944 онд хийсэн БНМАУ-ын хүн амын тооллогоор 759,1 мянган хүн тоологдсон³. Тухайн үед уг морьт отрядын эгнээнд нийт хүн амын 20 гаруй хувийг нэгтгэсэн цэрэг-олон түмний бие даасан байгууллага болсон байлаа.

1945 оны Чөлөөлөх дайнд 1000 гаруй хүнтэй морьт отряд оролцож байлдааны үүргээ нэр төртэй биелүүлсэн юм. 1944 онд Монголын баруун хилд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан хилийн сумдын ард иргэдийг зохион байгуулалттай зэвсэглэж, ардын сайн дурын 20-100 гаруй хүнтэй бүлгэмийг эмхлэн байгуулж, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн

² Доктор (Ph.D), профессор С.Баасанхүүгийн Зиндаа сайтад өгсөн ярилцлага. 2017.03.18 <https://news.zindaa.mn/1z3o>.

³ https://mn.wikipedia.org/wiki/Хүн_амын_тооллого

хилийн орчимд тусгай үүрэг гүйцэтгүүлсэн⁴ нь орон нутгийн хамгаалалтын бодит жишээ юм.

1960-аад оны дунд үеэс Монгол, Хятадын хооронд урьд өмнө тогтоосон бүхий л харилцаа, хамтын ажиллагаа зогсонги байдалд оржээ. Төр, засаг, МАХН-ын батлан хамгаалах салбарт баримталж ирсэн бодлогын нэг чухал чиглэл бол ард иргэдийг эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт бэлтгэх, цэргийн эрдэмд сургах явдал байв. Энэ ажлын хүрээнд ерөнхий боловсролын дунд сургуулийн 8-10 дугаар ангийн болон тусгай мэрэгжлийн сургууль, дээд сургуулийн эрэгтэй оюутан, сурагчидтай цэргийн анхан шатны бэлтгэл сургалтыг 3 жилд 116 цагаар явуулж байжээ.

1957 онд Ардын цэрэгт туслах сайн дурын нийгэмлэг байгуулагдсан. Энэ байгууллага нь 1970 оноос БНМАУ-ын Батлан хамгаалахад туслах нийгэмлэг болж өргөжээ. Хүүхэд залуучуудад цэргийн хэргийн мэдлэг дадлага олгох зорилготой тус нийгэмлэг нь сургалт, техникийн спорт, цэрэг эх оронч сурталчилгааны ажил эрхэлдэг олон нийтийн томоохон байгууллага байлаа. Энд буудлагын хичээл, үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах сургалт явагдаж байснаас гадна сургалтад хамрагчдаас сонгон шалгаруулж автомашины жолооч, засварчин, хүнд механизмын жолооч, мэргэн бууч, радист, шүхэрчин бэлтгэж байсан юм⁵.

Хоёр. Орон нутгийн хамгаалалтын өнөөгийн байдал

Хүйтэн дайн дуусаж, БНМАУ-ын аюулгүй байдлын баталгаа болсон ЗХУ-ын Улаан арми гарч явсан нь улс орны аюулгүй байдлыг хэрхэн хангах арга замыг эрэн хайх амаргүй зорилттой тулгарсан. 1992 онд баталсан Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-т Монгол Улсын иргэний үүрэгт “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” эрх зүйн зохицуулалт тусгаж өгсөн.

1993 онд УИХ-аас баталсан Батлан хамгаалах тухай хуульд “Монгол Улс гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс эх орноо өөрийн зэвсэгт хүчнээр, ард түмний оролцоотойгоор хамгаална. Шаардлагатай тохиолдолд НҮБ-ын дүрмийн дагуу бусад улсын тусламж авч болно” гэж заасан нь бүх нийтийн оролцоонд тулгуурласан батлан хамгаалах тогтолцоог сонгосон хэрэг болсон юм.

Өргөн уудам газар нутагтай, хүн ам цөөн, эдийн засгийн боломж сул, цэрэг, техникийн хувьд хоцрогдсон, хоёр их гүрний дунд оршдог байдлаа харгалзан төр, засгаас улс орныхоо батлан хамгаалах чадавхыг бүрдүүлэх хамгийн оновчтой арга бол орон нутгийн хамгаалалт гэж үзжээ⁶.

⁴ Н.Даваадорж, Баруун хилийн зэвсэгт тулгаралтын талаар “Өнөөдөр сонин”-д өгсөн ярилцлага, 2023.05.29-нд <https://www.unuudur.mn/a/256422>

⁵ С.Туул, Эвлэлээс төв зөвлөл хүрсэн түүх, 2009.06.29, <https://gogo.mn/r/55823>

⁶ Ц.Дашзэвэг, Ш.Паламдорж “Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын

Ингэхдээ гадны халдлага, түрэмгийллийг дан ганц Зэвсэгт хүчин хамгаалах боломжгүй, харин Монгол Улсын 3,5 сая иргэн бүр оролцож, нэгдэж чадвал сая эх орноо хамгаалах баталгаа, боломж бүрдэх юм.

УИХ-ын 2006 оны 98 дугаар тогтоолоор “Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого” батлагдаж, УИХ-аар 2016 онд батлагдсан Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т *“Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллага, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа байна”* хэмээн хуульчилсан.


УИХ-аас 2018 онд “Орон нутгийн хамгаалалтын тухай” анхдагч хуулийг батлав. Хуулийн гол үзэл санаа нь тайван цагт иргэдийг орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд сургах, учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг бүхий л түвшинд хангах, орон нутгийн хамгаалалтад төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдийн эрх үүргийг тогтоох явдал байв.

Мөн, Монгол Улсын батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх, онц болон дайны байдлын үед орон нутгаа хамгаалах замаар Монгол Улсыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс ард иргэдийн оролцоотойгоор батлан хамгаалах, иргэний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохицуулж өгсөн юм.

Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор олон ажил, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Засгийн газрын 2024 оны 41 дүгээр тогтоолоор Батлан хамгаалах яамны бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулж, Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны газрыг шинээр байгуулав. Батлан хамгаалахын сайдын тушаалаар бүх аймаг, нийслэл дэх Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудад орон нутгийн хамгаалалтын офицерын орон тоог шинээр бий болголоо.

Монгол Улсын орон нутгийн хамгаалалтын удирдлагын тогтолцооны хувьд улсын хэмжээнд орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг зохион байгуулах, хянан зохицуулах чиг үүргийг батлан хамгаалах яам, харин орон нутгийн хамгаалалтыг нутаг дэвсгэрийн зарчмаар аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.

Харин аймаг, нийслэл, дүүрэгт гардан зохион байгуулж буй нэгж нь цэргийн штабын мэргэжлийн офицерууд юм (1 дүгээр зураг).



1 дүгээр зураг. Монгол Улсын орон нутгийн хамгаалалтын удирдлагын тогтолцоо

Орон нутгийн тухай хуульд зааснаар аймаг нийслэл, сум дүүрэг бүр орон нутгаа хамгаалах төлөвлөгөөтэй байх ёстой. Энэ төлөвлөгөө бол орон нутгийн хамгаалалтын зохион байгуулалт удирдлага төлөвлөлтийн үндсэн баримт бичиг болно. Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр нэгдсэн удирдлага, төлөвлөлттэй болж, нөөц бүрдүүлэх, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалт бэлтгэлийг хангах боломж бүрдэх юм⁷.

Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөт ажил, арга хэмжээ, чиг үүргийг хэрэгжүүлэхэд албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийг бэлтгэх зорилгоор аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хамгаалалтын сургалтыг цугларалт, хээрийн дадлага, нэгдсэн сургууль хэлбэрээр явуулна. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд бүх 21 аймаг, нийслэлийн 6 дүүрэгт орон нутгийн хамгаалалтын сургалтыг явуулаад байна⁸.

Орон нутгийн хамгаалалтын талаарх гадны улс орнуудын туршлага, сургамжийг судлах нь чухал асуудал юм. Тухайлбал, Украинд явагдаж буй байлдааны ажиллагааны эхний сард янз бүрийн нас, хүйсний төрөл бүрийн мэргэжилтэй 110 мянган иргэд Украины орон нутгийн хамгаалах хүчинд

⁷ Цахим мэдээ, төв аймгийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг гардуулан өглөө. 2019.10.29, <https://www.zogii.mn/post/2109>

⁸ Булган: Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүйн сургалт боллоо. 2024.07.18, <https://dardas.mn/news/view/34521>

нэгдсэн нь бидний анхаарлыг татаж байгаа юм⁹. Цаашид Швейцар, Финланд, Норвег зэрэг орнуудын орон нутгийн хамгаалалтын туршлага сургамжийг судлах болно.

Түүнчлэн, ойрын хугацаанд дараах ажил, арга хэмжээг хийхээр төлөвлөж байна. Тухайлбал, орон нутгийн хамгаалалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөт ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутгийн сургалтыг эрчимжүүлэх, бүх аймаг, дүүргүүд жил бүр орон нутгийн хамгаалалтын сургалт дадлага явуулдаг болгох, тодорхой нөөц бүрдүүлэх, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний тоог өсгөх зэрэг болно.

Дүгнэлт

Орон нутгийн хамгаалалт бол монголчуудын эртнээс нутаг орон, бэлчээрээ хамгаалах уламжлалт аргын нэг байжээ. 21 дүгээр зуунд Монгол Улсын тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, дайн тулаанд орчин үеийн армитай мөр зэрэгцэн сайн дурын зэвсэглэсэн бүлгүүд үүрэг гүйцэтгэж байв. Монголчуудын олон мянган жилийн уламжлалт морьт цэрэг орчин үеийн механикжуулсан, мотобуудлагын цэрэг болсон ч гэсэн орон нутгийн цэргийн ач холбогдол буураагүй байна.

ЗХУ задран унасны дараа, Монгол Улс өөрийн хүчээр аюулгүй байдлаа хангах, эх орноо батлан хамгаалах шаардлага тулгарсан. Өргөн уудам газар нутагтай, хүн ам цөөн, эдийн засаг сул манай улсын хувьд дан ганц Зэвсэгт хүчин эх орноо хамгаалах боломжгүй гэдэг нь тодорхой болсон. Харин Монголчууд эв санаа, хүсэл зориг, үнэт зүйл дээр нэгдмэл байж, иргэдийн оролцоотой батлан хамгаалах тогтолцоог хуульчилсан нь манай улсын аюулгүй байдлыг баталгаа болж байна. Цаашид орон нутгийн хамгаалалтыг хөгжүүлэх, бэхжүүлэх нь батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны чухал чиглэл болж байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл

1. Д.Чулуунжав, “Монголын уналт, доройтлын нэг гол шалтгаан нь ламын шашин, мухар сүсэг” нийтлэл, 2017.04.21, <https://sonin.mn/news/politics-economy/77019>;
2. Доктор (Ph.D), профессор С.Баасанхүүгийн Зиндаа сайтад өгсөн ярилцлага. 2017.03.18 <https://news.zindaa.mn/1z3o>;
3. https://mn.wikipedia.org/wiki/Хүн_амын_тооллого;
4. Н.Даваадорж, Баруун хилийн зэвсэгт тулгаралтын талаар “Өнөөдөр сонин”-д өгсөн ярилцлага, 2023.05.29-нд <https://www.unuudur.mn/a/256422>;

⁹ Major General PLAKHUTA Ihor Viktorovych. Territorial Defense Forces <https://mod.gov.ua/en/about-us/territorial-defense-forces>

5. С.Туул, Эвлэлээс төв зөвлөл хүрсэн түүх, 2009.06.29, <https://gogo.mn/r/55823>;
6. Ц.Дашзэвэг, Ш.Паламдорж “Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын шинэчлэл” 2019 он, 76х.;
7. Цахим мэдээ, төв аймгийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг гардуулан өглөө. 2019.10.29, <https://www.zogii.mn/post/2109>;
8. Булган: Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалт боллоо. 2024.07.18, <https://dardas.mn/news/view/34521> ;
9. Major General PLAKHUTA Ihor Viktorovich. Territorial Defense Forces <https://mod.gov.ua/en/about-us/territorial-defense-forces>.